



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/260

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай” А/36 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, зөвлөн туслах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилгүүн
(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

А.Алтанцоож
(Цагдаагийн газрын дарга, цагдаагийн
хурандаа)

Ё.Пүрэвсүрэн
(Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Д.Түвшинбаяр
(Эрүүл мэндийн газрын дарга)

Ч.Дашбаяр
(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын дарга)

Б.Базардамбуу
(Статистикийн хэлтсийн дарга)

6710010171

Б.Мөнгөнзул
(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Л.Юмжирдулам
(Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

23 сумын Засаг дарга, 1 тосгоны захирагч

Нарийн бичгийн дарга:

Т.Раднаабүд
(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Дээрх судалгааны ажлыг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн мөн оны 06 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, холбогдох албан хаагчдыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР